# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 04 өдөр Дугаар А/724 Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" үндэсний хөтөлбөрийн 3.2, 6.4.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Бүтээлч Өвөрхангай-2020" хөтөлбөрийн 4.2 дахь бүлгийн 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдэд эрх зүйн анхан шатны дэмжлэг, туслалцаа үзүүлэх мэдлэг, чадвар дадал эзэмшүүлэх үүрэг бүхий "Эрх зүйн хөтөч" бэлтгэх сургалтад шаардагдах хөрөнгийг хавсралтаар батлсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2.329.380 ( хоёр сая гурван зуун хорин есөн мянга гурван зуун ная) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

0111101385

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 04-ны өдрийн А/724 дугаар
захирамжийн хавсралт

ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын төрөл | | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Цайны материал | Пироженое /Өв.санаа/ | ширхэг | 210 | 650 | 136.500 |
| | | Өндөгтэй талх /Өв.санаа/ | ширхэг | 51 | 1900 | 96.900 |
| | | Кофе, цай, ус бусад /Арцат/ | - | - | - | 155.580 |
| 2. | Үдийн хоол | Эрх зүйн хөтөч нар | ширхэг | 49 | 15000 | 735.000 |
| | | Сургагч багш 2 удаа | ширхэг | 11 | - | 215.400 |
| 3. | Буудал | | 2 хоног | 3 хүн | 80.000 | 320.000 |
| 4. | Сургалтын гарын авлага | | ширхэг | 55 | 10000 | 550.000 |
| 5. | Мэдээллийн тавиур | | ширхэг | 2 | 60.000 | 120.000 |
| | | | | Нийт дүн 2.329.380 | | |

-оОо-